



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 317

Улаанбаатар хот

“Итгэлт капитал” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Итгэлт капитал” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Итгэлт капитал ББСБ” ХХК /С.Энхбат/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны бүртгэлд бүргэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000899